

## ***ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА***

**Огноо:** 2018.10.03

**Тендер шалгаруулалтын нэр:** Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сумдын 0,4, 0,22 кВ-ын модон тулгууртай цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетон тулгууртай СИП шугамаар солих, дэд станцын өргөтгөл” төсөл, арга хэмжээ БАГЦ-1

**Тендер шалгаруулалтын дугаар:** ЭХА/201812007-01

Эрчим хүчний яам эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сумдын 0,4, 0,22 кВ-ын модон тулгууртай цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетон тулгууртай СИП шугамаар солих, дэд станцын өргөтгөл” төсөл, арга хэмжээний хүрээнд Баянхонгор, Сэлэнгэ, Төв аймгуудад хэрэгжих ажлыг гүйцэтгэх цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валлотаар цахим тендерийн хураамж төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Борлуулалтын хэмжээ: *Сүүлийн 3 жилийн /2015, 2016, 2017/ онуудын борлуулалтын орлогын аль нэгэн жилд нь тухайн багцын Тендерт оролцогчийн санал болгож буй тендерийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.*
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: *Тухайн багцын төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.*
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:
  - *Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч: Эрчим хүчний сайдын 03.2.1: 0.4-10 кВ Цахилгаан түгээх шугам, дэд станцын угсралт, засвар, туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ.*
  - *Зураг төсөл боловсруулах гүйцэтгэгч: Эрчим хүчний сайдын 03.9.3: Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг, төсөл боловсруулах 0.4-35 кВ тусгай зөвшөөрөлтэй байна.*

Тендерийн хамт 11,600,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 11:00 цагаас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 11 дүгээр сарын 02-ны 11:30 цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

17060 Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.  
Чингисийн өргөн чөлөө. Эрчим хүчний яам.  
Засгийн газрын ХИҮ байр.  
давхар. 306 тоот өрөө. Утас: 62263072  
[www.energy.gov.mn](http://www.energy.gov.mn)